



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дундговь аймгийн Өлзийт сумын Засаг даргын Тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ДУА-2025/26/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

Дундговь аймаг

2025 он

Аудитын газрын дарга,  
тэргүүлэх аудитор: Р.Мөнхтогтох  
Утас: 70592439  
Цахим хаяг: [Munkhtogtokhr@audit.gov.mn](mailto:Munkhtogtokhr@audit.gov.mn)

Аудитын менежер: Т.Оюун-Эрдэнэ  
Утас: 70592225  
Цахим хаяг: [Oyunerdenet@audit.gov.mn](mailto:Oyunerdenet@audit.gov.mn)

Ахлах аудитор: Т.Батсайхан  
Утас: 70593113  
Цахим хаяг: [Batsaikhant@audit.gov.mn](mailto:Batsaikhant@audit.gov.mn)

Аудитор: Б.Мягмарсүрэн  
Утас: 70593113  
Цахим хаяг: [Myagmarsurenby@audit.gov.mn](mailto:Myagmarsurenby@audit.gov.mn)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга.....	0
<b>1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ .....</b>	<b>2</b>
<b>2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....</b>	<b>4</b>
<b>2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....</b>	<b>4</b>
<b>2.1 Аудит хийсэн санхүү үр дүнгийн тайлан .....</b>	<b>4</b>
<b>2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан /төгрөгөөр/.....</b>	<b>6</b>
<b>2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан /төгрөгөөр/.....</b>	<b>7</b>
<b>2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....</b>	<b>8</b>
<b>2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан .....</b>	<b>9</b>
<b>3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....</b>	<b>Error! Bookmark not defined.</b>
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа .....	<b>Error! Bookmark not defined.</b>
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин .....	<b>Error! Bookmark not defined.</b>
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	<b>Error! Bookmark not defined.</b>
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд .....	<b>Error! Bookmark not defined.</b>
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	<b>Error! Bookmark not defined.</b>
<b>4. АУДИТЫН ТАЙЛАН .....</b>	<b>Error! Bookmark not defined.</b>
<b>4.1 Ерөнхий зүйл.....</b>	<b>Error! Bookmark not defined.</b>
<b>4.2 Материаллаг байдал.....</b>	<b>Error! Bookmark not defined.</b>
<b>4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт .....</b>	<b>Error! Bookmark not defined.</b>
<b>4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал..</b>	<b>Error! Bookmark not defined.</b>
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	<b>Error! Bookmark not defined.</b>
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	<b>Error! Bookmark not defined.</b>
<b>5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ .....</b>	<b>9</b>
<b>5.2 Албан шаардлага.....</b>	<b>10</b>
<b>6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....</b>	<b>16</b>

#### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт

АДБОУС Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт

## 1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дундговь аймгийн Өлзийт сумын Засаг даргын Тамгын газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол Дундговь аймгийн Өлзийт сумын Засаг даргын Тамгын газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

### Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Өлзийт сумын Засаг даргын Тамгын газар нь 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар төсвөөс гаргах баяр наадмын зардлыг санхүүжилтийн жишиг дээд хэмжээнээс хэтрүүлэн зарцуулсан, жолоочийн тооцоо бодоогүй, санхүүгийн тайлан дахь өглөг, авлагыг алдаатай тайлагнасан, зэрэг 46.1 сая төгрөгийн материаллаг зөрчил нь тооцоолсон материаллаг байдлын түвшнээс 3.7 дахин их байна.

Дээрх зөрчил нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5, 20.2.6, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, Засгийн газрын 2010 оны 271 дугаар тогтоолын "Жишиг хэмжээг шинэчлэн тогтоох тухай /наадмын санхүүжилт/-ийн 1-д заасан заалтуудтай нийцэхгүй, эрх ба үүрэг, оршин байх, нийцсэн бөгөөд зохистой байх мэдэгдлүүдийг хангахгүй байна.

### Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Санхүүгийн тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой зүйлийн талаар тодруулахад Монгол улсын Засгийн газрын шийдвэрээр 2024 оны 04 сарын сарын 01-ээр төрийн албаны үндсэн цалин нэмсэн, бүх төрийн албан хаагчдад орон нутгийн нэмэгдлийг олгож эхэлсэнтэй холбоотой цалингийн зардал өмнөх оноос 1.5 дахин өссөн байна. Мөн орон нутагт тогтвор суурьшилтай 5 жил ажилласны тэтгэмжийг төрийн захиргааны албан хаагчдад олгож эхэлснээр 2024 онд 2 албан хаагч 16.5 сая төгрөгийн

4825020159

дэмжлэг авсан байна. Уг үйл явцыг санхүүгийн тайланд толилуулсан бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй асуудал гараагүй болно.

Мөн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны "Сумын эмийн эргэлтийн сан ОНӨААТҮГ-уудыг татан буулгах тухай" 16 дугаар тогтоолын дагуу сумын Эмийн эргэлтийн санг татан буулгаж, үлдэгдэл хөрөнгө болон өр төлбөрийг санхүүгийн тайланд нэгтгэсэн онцлог бүртгэл хийгджээ.

Тус байгууллагын чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй бөгөөд үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй.

#### **Аудитын гол асуудал**

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад материаллаг буруу тайлагналын өндөр үнэлэгдсэн эрсдэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал, тайлант хугацаанд гарсан нөлөө бүхий ажил гүйлгээ, үйл явдал байхгүй байна.

#### **Бусад асуудал**

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй зохистой гэж үзлээ. Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 6 зорилт, 144 заалттай, 16 арга хэмжээг хэрэгжүүлж, гүйцэтгэлийн төлөвлөгөөний үнэлгээгээр 90.1 хувьтай үнэлэгдсэн байна.

#### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


#### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Р.МӨНХТОГТОХ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Данс	Балансын зүйл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
I	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	196,192,055.20	192,721,936.23
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	9,603,376.00	6,803,370.00
312	Банканд байгаа бэлэн мөнгө	9,603,376.00	6,803,370.00
3121	Төгрөг	9,603,376.00	6,803,370.00
31213	Арилжааны банк дахь харилцах	6	
31214	Бусад төсөл, нөөцийн харилцах	9,603,370.00	6,803,370.00
33	АВЛАГА	479,159.20	224,649.23
331	Ажиллагчидтай холбогдсон авлага	479,159.20	224,649.23
35	БАРАА МАТЕРИАЛ	186,109,520.00	185,693,917.00
351	Түүхий эд материал	2,270,500.00	2,660,400.00
3511	Тусгай зориулалттай материал	2,270,500.00	2,660,400.00
354	Хангамжийн материал	176,564,020.00	175,758,517.00
3541	Бичиг хэргийн материал	3,117,498.00	3,394,298.00
3542	Аж ахуйн материал	171,553,122.00	169,975,619.00
3545	Барилгын засварын материал	1,893,400.00	2,388,600.00
356	Мал амьтад	7,275,000.00	7,275,000.00
36	НӨӨЦИЙН БАРАА		
II	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	4,354,857,768.20	4,869,531,399.85
37	УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ		
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	4,354,857,768.20	4,869,531,399.85
392	Биет хөрөнгө	4,182,282,763.20	4,696,956,394.85
39201	Барилга, байгууламж, орон сууц	4,876,550,062.07	5,440,817,274.07
39202	Хуримтлагдсан элэгдэл	1,046,169,328.99	-1,317,695,641.10
39203	Авто-тээврийн хэрэгсэл	129,484,658.55	241,782,158.55
39204	Хуримтлагдсан элэгдэл	-68,044,879.01	-86,440,477.57
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	307,272,108.00	346,870,964.93
39206	Хуримтлагдсан элэгдэл	-216,876,112.85	-195,721,251.34
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	132,568,054.00	199,252,444.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-95,754,798.57	-95,162,076.69
39214	Бусад үндсэн хөрөнгө	163,253,000.00	163,253,000.00
393	Биет бус хөрөнгө	172,575,005.00	172,575,005.00
39301	Программ хангамж	5,136,625.00	5,136,625.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-350,000.00	-350,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	167,788,380.00	167,788,380.00
III	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	4,551,049,823.40	5,062,253,336.08
IV	НИЙТ ӨР ТӨЛБӨР	3,175,111.50	
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	3,175,111.50	
413	Өглөг	3,175,111.50	
4132	Бараа үйлчилгээний зардлын өглөг	3,175,111.50	
V	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	4,547,874,711.90	5,062,253,336.08
51	Засгийн газрын хувь оролцоо	4,547,874,711.90	5,062,253,336.08
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	892,803,037.00	892,803,037.00
5E+05	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	892,803,037.00	892,803,037.00
512	Хуримтлагдсан үр дүн	3,655,071,674.90	4,169,450,299.08
5121	Өмнөх үеийн үр дүн	3,655,071,674.90	3,654,592,515.70
5122	Тайлант үеийн үр дүн		514,857,783.38
VI	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	4,551,049,823.40	5,062,253,336.08

### 2.1 Аудит хийсэн санхүү үр дүнгийн тайлан

Данс	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,518,018,481.00	1,764,530,850.86

12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	834,724,032.00	771,416,692.93
120	Нийтлэг татварын бус орлого	834,724,032.00	771,416,692.93
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	7,488,370.00	4,000,000.00
1E+06	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	7,488,370.00	4,000,000.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	789,705,142.00	746,478,151.93
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	37,530,520.00	20,938,541.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	683,294,449.00	993,114,157.93
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	94,714,949.00	80,244,457.93
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	7,000,000.00	8,200,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	21,246,758.00	30,193,958.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	66,468,191.00	41,850,499.93
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	588,579,500.00	912,869,700.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	588,579,500.00	912,869,700.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих		
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	908,981,223.49	1,235,557,576.48
21	УРСГАЛ ЗАРДАЛ	908,981,223.49	1,235,557,576.48
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	856,089,878.77	1,120,278,558.80
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	311,186,170.42	470,222,736.65
210101	Үндсэн цалин	226,041,524.74	299,955,446.09
210102	Нэмэгдэл	52,212,604.01	141,250,017.56
210104	Урамшуулал	32,932,041.67	29,017,273.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	38,357,952.10	55,064,516.06
210201	Тэтгэврийн даатгал	26,598,015.76	35,757,811.96
210202	Тэтгэмжийн даатгал	3,126,476.13	5,034,510.19
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,508,629.02	2,517,305.44
210204	Ажилгүйдлийн даатгал	549,426.17	2,351,017.60
210205	Эрүүл мэндийн даатгал	5,575,405.02	9,403,870.87
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	43,801,020.71	49,622,277.21
210301	Гэрэл, цахилгаан	21,335,079.14	18,535,602.15
210302	Түлш, халаалт	19,891,441.57	30,586,675.06
210303	Цэвэр, бохир ус	2,574,500.00	500,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	59,222,081.00	68,445,331.00
210401	Бичиг хэрэг	3,478,200.00	1,140,400.00
210402	Тээвэр, шатахуун	40,755,915.00	45,936,400.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,240,850.00	293,500.00
210405	Хог хаягдал зайлуулах, хоргон мэрэгчдийн устгал, ариутгал	300,000.00	1,654,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	12,733,070.00	106,000.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	714,046.00	
210408	Бараа материал акталсны зардал		19,315,031.00
2105	Нормативт зардал		
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	7,151,300.00	12,382,300.00
210604	Урсгал засвар	7,151,300.00	12,382,300.00
2107	Томилолт, зочны зардал	12,936,000.00	14,636,000.00
210702	Дотоод албан томилолт	12,936,000.00	14,636,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	8,235,586.60	27,909,084.20
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6,826,858.00	24,921,924.00
210803	Даатгалын үйлчилгээ	245,025.00	212,250.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	282,041.60	984,182.20
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	88,000.00	121,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	360,000.00	
210807	Газрын төлбөр	433,662.00	1,669,728.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	375,199,767.94	421,996,313.68
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	115,676,315.84	88,541,793.40

210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,335,000.00	2,750,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	256,188,452.10	330,704,520.28
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	52,891,344.72	115,279,017.68
2132	Бусад урсгал шилжүүлэг	8,550,000.00	27,525,583.28
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж		2,000,000.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	8,550,000.00	
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж		7,916,583.28
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг		15,609,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		2,000,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	44,341,344.72	87,753,434.40
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	27,375,573.79	87,753,434.40
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	16,965,770.93	
	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>		
	Дотоод эх үүсвэрээр		
III	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	609,037,257.51	528,973,274.38
145	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН</b>		
225	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	792,811.86	14,115,491.00
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	792,811.86	
225011	Үнэ төлбөргүй гарсан зардал - Бараа материал		14,115,491.00
IV	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	-792,811.86	-14,115,491.00
V	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	608,244,445.65	514,857,783.38

**2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

/төгрөгөөр/

Данс	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	688,397,819.09	997,114,157.93
12	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	5,103,370.00	4,000,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	5,103,370.00	4,000,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	5,103,370.00	4,000,000.00
1E+06	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		4,000,000.00
1E+06	Шилжиж ирсэн мөнгөн хөрөнгө	5,103,370.00	
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	683,294,449.09	993,114,157.93
1310	Улсын төвлөрсөн төсвөөс		
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	94,714,949.09	80,244,457.93
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	7,000,000.00	8,200,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	21,246,758.00	30,193,958.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	66,468,191.09	41,850,499.93
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	588,579,500.00	912,869,700.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	588,579,500.00	912,869,700.00
II	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	656,736,066.09	901,014,163.93
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	656,736,066.09	901,014,163.93
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	598,730,721.37	785,735,146.25
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	311,686,237.80	468,671,940.00
210101	Үндсэн цалин	226,319,041.37	298,404,649.44
210102	Нэмэгдэл	52,162,604.01	141,250,017.56
210104	Урамшуулал	33,204,592.42	29,017,273.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	38,337,043.92	56,839,961.94
210201	Тэтгэврийн даатгал	26,604,544.79	37,533,257.84
210202	Тэтгэмжийн даатгал	3,126,475.77	5,034,510.19
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,496,484.70	2,517,305.44
210204	Ажилгүйдлийн даатгал	564,494.13	2,351,017.60
210205	Эрүүл мэндийн даатгал	5,545,044.53	9,403,870.87
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	40,625,909.21	52,797,388.71
210301	Гэрэл, цахилгаан	21,335,079.14	18,535,602.15
210302	Түлш, халаалт	16,716,330.07	33,761,786.56

210303	Цэвэр, бохир ус	2,574,500.00	500,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	37,567,235.00	42,892,650.00
210401	Бичиг хэрэг	3,713,350.00	3,285,000.00
210402	Тээвэр, шатахуун	28,576,915.00	35,708,100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,240,850.00	293,500.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	300,000.00	1,654,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,736,120.00	1,952,050.00
2105	Нормативт зардал	2,579,000.00	1,100,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,579,000.00	1,100,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	12,032,500.00	15,053,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	455,000.00	
210604	Урсгал засвар	11,577,500.00	15,053,000.00
2107	Томилолт, зочны зардал	12,936,500.00	14,636,000.00
210702	Дотоод албан томилолт	12,936,500.00	14,636,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,239,703.60	31,293,738.20
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,076,000.00	28,306,578.00
210803	Даатгалын үйлчилгээ		212,250.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	282,041.60	984,182.20
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	88,000.00	121,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	360,000.00	
210807	Газрын төлбөр	433,662.00	1,669,728.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	140,726,591.84	102,450,467.40
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	137,391,591.84	99,700,467.40
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,335,000.00	2,750,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	58,005,344.72	115,279,017.68
2132	Бусад урсгал шилжүүлэг	13,664,000.00	27,525,583.28
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	4,500,000.00	2,000,000.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	8,550,000.00	
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж		7,916,583.28
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг		15,609,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	614,000.00	2,000,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	44,341,344.72	87,753,434.40
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	27,375,573.79	87,753,434.40
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	16,965,770.93	
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	31,661,753.00	96,099,994.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	22,948,000.00	98,900,000.00
	Дотоод эх үүсвэрээр	22,948,000.00	98,900,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	22,948,000.00	98,900,000.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-22,948,000.00	-98,900,000.00
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	8,713,753.00	-2,800,006.00
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		9,603,376.00
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		6,803,370.00

**2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

/төгрөгөөр/

Д/Д	Үзүүлэлт	Засгийн газрын сан	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	ЗГ-н хувь оролцооны дүн
1	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	892,803,037.00		3,132,564,050.72	4,025,367,087.72
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			-479,159.20	-479,159.20
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт				
7	Тайлант үеийн үр дүн			522,986,783.38	522,986,783.38

10	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	892,803,037.00		3,655,071,674.90	4,547,874,711.90
11	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			-479,159.20	-479,159.20
17	Тайлант үеийн үр дүн			514,857,783.38	514,857,783.38
19	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	892,803,037.00		4,169,450,299.08	5,062,253,336.08

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Д/Д	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү дүн
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	917,399,746.00	839,464,429.32	77,935,316.68
21	УРСГАЛ ЗАРДАЛ	818,499,746.00	740,564,429.32	77,935,316.68
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	789,058,946.00	713,038,846.04	76,020,099.96
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	520,860,200.00	468,671,940.00	52,188,260.00
210101	Үндсэн цалин	326,674,700.00	298,404,649.44	28,270,050.56
210102	Нэмэгдэл	145,017,500.00	141,250,017.56	3,767,482.44
210104	Урамшуулал	39,168,000.00	29,017,273.00	10,150,727.00
210105	Гэрээт ажлын хөлс	10,000,000.00		10,000,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	68,218,600.00	56,839,961.94	11,378,638.06
210201	Тэтгэврийн даатгал	46,388,500.00	37,533,257.84	8,855,242.16
210202	Тэтгэмжийн даатгал	5,457,500.00	5,034,510.19	422,989.81
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,728,800.00	2,517,305.44	211,494.56
210204	Ажилгүйдлийн даатгал	2,728,800.00	2,351,017.60	377,782.40
210205	Эрүүл мэндийн даатгал	10,915,000.00	9,403,870.87	1,511,129.13
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	40,961,800.00	40,012,172.50	949,627.50
210301	Гэрэл, цахилгаан	5,750,400.00	5,750,385.94	14.06
210302	Түлш, халаалт	33,761,800.00	33,761,786.56	13.44
210303	Цэвэр, бохир ус	1,449,600.00	500,000.00	949,600.00
2104	Хангамж, бараа материалын зардал	48,346,746.00	42,892,650.00	5,454,096.00
210401	Бичиг хэрэг	3,433,500.00	3,285,000.00	148,500.00
210402	Тээвэр, шатахуун	36,893,700.00	35,708,100.00	1,185,600.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	689,500.00	293,500.00	396,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	4,654,000.00	1,654,000.00	3,000,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,962,000.00	1,952,050.00	9,950.00
2105	Нормативт зардал	1,100,000.00	1,100,000.00	
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,100,000.00	1,100,000.00	
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	15,100,000.00	15,053,000.00	47,000.00
210604	Урсгал засвар	15,100,000.00	15,053,000.00	47,000.00
2107	Томилолт, зочны зардал	15,340,000.00	14,636,000.00	704,000.00
210702	Дотоод албан томилолт	15,340,000.00	14,636,000.00	704,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	13,325,300.00	11,748,854.20	1,576,445.80
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	8,761,700.00	8,761,700.00	
210803	Даатгалын үйлчилгээ	429,800.00	212,250.00	217,550.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	1,014,200.00	984,182.20	30,017.80
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	210,000.00	121,000.00	89,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	684,000.00		684,000.00
210807	Газрын төлбөр	2,225,600.00	1,669,728.00	555,872.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж		-6.00	6.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	65,806,300.00	62,084,267.40	3,722,032.60

210901	Бараа үйлчилгээний бусад зардал	63,056,300.00	59,334,267.40	3,722,032.60
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,750,000.00	2,750,000.00	
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	29,440,800.00	27,525,583.28	1,915,216.72
2132	Бусад урсгал шилжүүлэг	29,440,800.00	27,525,583.28	1,915,216.72
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	2,000,000.00	2,000,000.00	
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	8,270,800.00	7,916,583.28	354,216.72
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	16,520,000.00	15,609,000.00	911,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,650,000.00	2,000,000.00	650,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	98,900,000.00	98,900,000.00	
	Дотоод эх үүсвэрээр	98,900,000.00	98,900,000.00	
223001	Бусад хөрөнгө	98,900,000.00	98,900,000.00	
1	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	916,685,700.00	839,464,429.32	77,221,270.68
132	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	914,685,700.00	837,464,429.32	77,221,270.68
132001	Орон нутгийн төсвөөс	914,685,700.00	837,464,429.32	77,221,270.68
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	2,000,000.00	2,000,000.00	
1E+06	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,000,000.00	2,000,000.00	

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Д/Д	Үзүүлэлт	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	80,244,457.93
21	УРСГАЛ ЗАРДАЛ	80,244,457.93
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	67,896,294.21
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	12,785,216.21
210301	Гэрэл, цахилгаан	12,785,216.21
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	19,544,878.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	19,544,878.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	35,566,200.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	35,566,200.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	12,348,163.72
2132	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	12,348,163.72
1	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	80,244,457.93
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	80,244,457.93
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	8,200,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	30,193,958.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	41,850,499.93

## 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 61,657.1 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс аудитын явцад 15,527.7 мянган төгрөгийн 3 алдааг залруулж, 44,397.3 мянган төгрөгийн 6 албан шаардлага, сахилгын шийтгэл ногдуулах 1 албан шаардлага, 1,732.1 мянган төгрөгний 1 төлбөрийн акт, 1 зөвлөмжийг тус тус хүргүүлээ.

### Залруулсан алдаа:

Аудитаар нийт 15,527.7 мянган төгрөгийн зөрчил илэрч, аудитын явцад бүрэн залрууллаа. Үүнд:

- Авлагын тодруулга тайланд 479.2 мянган төгрөгийн цалин илүү тайлагнасан. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.5-д /дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;/ заасныг зөрчсөн.

- Өглөгийн тодруулга тайланд 1,703.1 мянган төгрөгийн байгууллагад өгөх өглөгийг илүү тайлагнасан. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.5-д /дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;/ заасныг зөрчсөн.
- Зарцуулагдсан 14,345.4 мянган төгрөгийн бараа материалыг бүртгэлээс хасаагүй, үлдэгдлээр тайлагнасан. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д /Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална/, 5.1.4-т /үнэн зөв байх/, 6.1-т /Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккруэл сууриар хөтөлнө/ тус тус заасныг зөрчсөн байна.

### **Залруулагдаагүй алдаа:**

Аудитаар нийт 46,129.4 мянган төгрөгийн зөрчил илэрч, зөрчил арилгах акт, албан шаардлага хүргүүлээ.

#### **3.1 Төлбөрийн акт**

- Сахилгын шийтгэлтэй албан хаагчид гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт, ажил үүрэг, үр дүнг тооцон 1,732.1 мянган төгрөгийн үр дүнгийн урамшуулал тооцож олгосон. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2-т /Батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих/, Төрийн албаны тухай хуулийн 48.7-д /Төрийн жинхэнэ албан хаагч сахилгын шийтгэл ногдуулсан өдрөөс хойш 1 жилийн дотор сахилгын шийтгэл хүлээгээгүй бол түүнийг сахилгын шийтгэлгүйд тооцно./, Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журмын 2.7-д /Хууль тогтоомжийн дагуу сахилгын шийтгэл хүлээсэн төрийн албан хаагчийн сахилгын шийтгэлгүйд тооцогдох хугацаа дуусаагүй бол тухайн төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулал олгохгүй/ заасныг зөрчсөн байна.

*Шийдвэрлэсэн нь: Илүү тооцож олгосон 1,732.1 мянган төгрөгийг Дундговь аймгийн Төрийн сан банк дахь 100080000955 тоот дансанд төвлөрүүлэхээр төлбөрийн акт тогтоосон.*

#### **3.2 Албан шаардлага**

- Баяр наадмын зардлыг төсвөөс гаргах санхүүжилтийн жишиг дээд хэмжээнээс 19,980.8 мянган төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх /Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах/, Засгийн газрын 2010 оны 271 дугаар тогтоолын "Жишиг хэмжээг шинэчлэн тогтоох тухай /наадмын санхүүжилт/", Үндэсний их баяр наадмын тухай хуулийн 11.1.5-ыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь 1-д /Үндэсний их баяр наадмын арга хэмжээнд зориулан төсвөөс гаргах санхүүжилтийн жишиг дээд хэмжээг аймагт 10.0 (арван) сая төгрөг, суманд 5.0 (таван) сая төгрөг байхаар тус тус тогтоож, бөх, уяач, харваачдад төсвөөс олгох бай, шагналын жишиг хэмжээг хавсралт ёсоор шинэчлэн баталсугай/ заасныг тус тус зөрчсөн.
- Гадны машинаар ажил гүйцэтгүүлэхдээ гэрээ байгуулаагүй 5,446.4 мянган төгрөгийн шатахуун олгох зөвшөөрлийн бичиг тараах жагсаалтын хуудсанд гарын үсэг зуруулаагүй. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 зүйлийн 16.5.2 /батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих/, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4. /Аж ахуйн нэгж байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат, дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна/, Зам тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 390 дугаар тушаалын 1-р хавсралт /Автомашин 100 км гүйлтэд зарцуулах шатахуун зарцуулалтын жишиг нормыг үндэслэн тогтоож, мөрдөж ажиллах, шатахууны зарцуулалтын тооцоог тогтсон хугацаанд бодож, тооцоо бодсон актыг үйлдэж баталгаажуулах/ заасныг тус тус зөрчсөн.
- Ажил олгогчоос төлөх 1,550.8 мянган төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийг цалингийн сангаас шилжүүлсэн. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх /Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах/, Төрийн албаны тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.1.4 дэх /улирлын ажлын үр дүнгээр мөнгөн урамшуулал

олгох/, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх /Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно/ 15.1.3 дахь /Хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох/, Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан “Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам”-ын 2.2 дахь “/Төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллын дээд хэмжээ нь албан хаагчийн албан тушаалын сарын үндсэн цалингийн 50 хувиас хэтрэхгүй байна/ заасныг тус тус зөрчсөн.

- Шатахууны 14,151.4 мянган төгрөгийн тооцоо бодож, үлдэгдлийг баталгаажуулаагүй. Энэ Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.5-д /дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;/, мөн хуулийн 20.2.6-д /эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах/ заасныг тус тус зөрчсөн.
- Орон сууц болон цайны газрын түрээсийн 3,267.9 мянган төгрөгийн орлогыг дутуу төвлөрүүлсэн. Энэ Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.5-д /дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;/, мөн хуулийн 20.2.6-д /эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах/ заасныг тус тус зөрчсөн.
- Үндсэн хөрөнгийн тооллогыг чанаргүй хийж, тооцоо бодсон акт зөрүүтэй үйлдсэн. Энэ Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.5-д /дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;/, мөн хуулийн 20.2.6-д /эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах/ заасныг тус тус зөрчсөн.

*Шийдвэрлэсэн нь: Жилийн эцсийн аудитаар зөрчлийг таслан зогсоох б албан шаардлага хүргүүлээ.*

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

##### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл:

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс			
							Залруулсан		Залруулаагүй	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Авлагын тодруулга тайланд цалин илүү тайлагнасан.	1	479.2			1	479.2	1	479.2		
Өглөгийн тодруулга тайланд байгууллагад өгөх өглөгийг илүү тайлагнасан	1	1,703.1			1	1,703.1	1	1,703.1		
Зарцуулагдсан бараа материалыг бүртгэлээс хасаагүй, үлдэгдлээр тайлагнасан	1	13,345.4			1	13,345.4	1	13,345.4		
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>15,527.7</b>			<b>1</b>	<b>15,527.7</b>	<b>1</b>	<b>15,527.7</b>		

##### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл :

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс							
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Баяр наадмын зардлыг төсвөөс гаргах санхүүжилтийн жишиг дээд хэмжээнээс хэтрүүлэн зарцуулсан.	1	19,980.8			1	19,980.8				
Сахилгын шийтгэлтэй албан хаагчид гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт, ажил үүрэг, үр дүнг тооцон үр дүнгийн урамшуулал тооцож олгосон.	1	1,732.1	1	1,732.1						
Гадны машинаар ажил гүйцэтгүүлэхдээ гэрээ байгуулаагүй, шатахуун олгох зөвшөөрлийн бичиг тараах жагсаалтын хуудсанд гарын үсэг зуруулаагүй.	1	5,446.4			1	5,446.4				
Шатахууны тооцоо бодож, үлдэгдлийг баталгаажуулаагүй	1	14,151.4			1	14,151.4				
Орон сууц болон цайны газрын түрээсийн орлогыг дутуу төвлөрүүлсэн.	1	3,267.9			1	3,267.9				
Ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийг цалингийн сангаас шилжүүлсэн.	1	1,550.8			1	1,550.8				
Үндсэн хөрөнгийн тооллогыг чанаргүй хийж, тооцоо бодсон акт зөрүүтэй үйлдсэн.	1	0.0			1	0.0				
Өмнөх аудитаар өгсөн албан шаардлагуудыг хэрэгжүүлээгүй, зөрчлийг давтан гаргасан.	1	0.0							1	0.0
<b>Дүн</b>	<b>8</b>	<b>46,129.4</b>	<b>1</b>	<b>1,732.1</b>	<b>6</b>	<b>44,397.3</b>			<b>1</b>	<b>0</b>

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил									
Тайлант хугацаанд мэдээлэх хөрөнгө зарцуулахтай холбоотой 17 шийдвэрээс 14 шийдвэрийг дутуу мэдээлсэн.	1	0.0							1	0.0
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>0.0</b>							<b>1</b>	<b>0.0</b>
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил										
<b>Дүн</b>										

**5. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл**

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс тагталсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1				1		
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ								
5	ТЕЗ								
	<b>НИЙТ</b>	<b>1</b>	<b>1</b>				<b>1</b>		

